


БАТЛАВ:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД



Ц.НЯМДОРЖ

## ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

### Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах дараах хууль зүйн үндэслэл, практик шаардлага байна.

#### 1.1.Хууль зүйн үндэслэл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэний эрх, үүргийг Монгол Улсын хууль, уул иргэнийг харьяалсан улстай байгуулсан гэрээгээр тогтооно” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “Монгол Улс нутаг дэвсгэртээ байгаа харьяалалгүй хүний эрх, үүргийг өөрийн хуулиар тогтооно” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 161-д “Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах эрх олгох, сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих бүрэн эрхийн хүрээнд хүсэлтийг шийдвэрлэх хугацаа, иргэдээс бүрдүүлэх баримт бичиг, хүсэлтийг буцаах үндэслэл зэрэг асуудлаар журам батлах эрхийг эрх бүхий этгээдэд олгох чиглэлээр нэмэлт, өөрчлөлт оруулна” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.4-т “... жуулчин хүлээн авах хүчин чадлыг сайжруулж, гадаад жуулчдын тоог нэмэгдүүлж, хил дээр олгодог цахим виз, визийн дэвшилтэт төрлүүдийг бий болгоно.” гэж, 5.3.12-т “Гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг онлайн хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулна.” гэж тус тус заасан байна.

#### 1.2.Практик шаардлага

Монгол Улсын Их Хурал 2010 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталсан бөгөөд уг хуульд 2012, 2013, 2015, 2016, 2017, 2018, 2019 онуудад нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд эдгээр нь Хилийн боомтын тухай, Хилийн тухай, Зөрчлийн тухай, Чөлөөт бүсийн тухай, Улсын бүртгэлийн тухай, Татварын тухай зэрэг хуулиудтай холбогдуулан нэр томъёоны өөрчлөлт хийх агуулгатай байсан байна.

Төрийн үйлчилгээ цахим хэлбэрт шилжиж байгаа цаг үед гадаадын иргэнд үзүүлэх зарим үйлчилгээг мөн цахим хэлбэрт шилжүүлж, бүртгэл, хяналтыг сайжруулах шаардлага зүй ёсоор тулгарч байгаа бөгөөд виз олгох үйлчилгээг цахимаар олгох боломжтой болсонтой холбоотойгоор түүний эрх зүйн үндсийг хуульд бий болгох, Монгол Улсын визийн тухай ойлголтыг өргөтгөж, тодорхойлолтыг өөрчлөх, визийн ангиллыг төрөлжүүлж, олшруулах боломжийг бүрдүүлэх шаардлагатай байна.

Дэлхийн эдийн засгийн форумаас гаргадаг “Аялал жуулчлалын өрсөлдөх чадварын үзүүлэлт”-д дэлхийн 140 орноос Монгол Улс нийлбэр дүнгээр 93 дугаарт, “олон улсад нээлттэй байдал” буюу **жуулчны виз олгох нөхцөлийн үзүүлэлтээр 128-д**, “газрын боомтын дэд бүтцийн хөгжил” үзүүлэлтээр 126-д, “жуулчны үйлчилгээний дэд бүтэц” үзүүлэлтээр 105-д, “агаарын тээврийн дэд бүтэц” үзүүлэлтээр 97 дугаарт тус тус эрэмбэлэгдсэн байна. Иймд виз олгохтой холбоотой нөхцөлийг хөнгөвчлөх, шийдвэрлэх замаар Монгол Улс олон улс болон бүс нутагтаа өрсөлдөх чадвараа дээшлүүлж, аялал жуулчлалын хөгжлийг эрчимжүүлэх шаардлага урган гарч байна.

Монгол Улсын визийн хүчинтэй хугацаа нь бусад улс оронтой харьцуулахад харьцангуй богино байгаа бөгөөд энэ нь олон улс орноор дамжин аялал хийж байгаа болон аяллаа эртнээс төлөвлөдөг гадаад иргэдийн хувьд хүндрэл үүсгэдэг тул үүнийг өөрчилж олон улсын жишгийн дагуу визийн хүчинтэй байх хугацааг одоо байгаагаас уртасгах нь гадаадын иргэдэд учрах хүндрэлийг бууруулах, тоог нэмэгдүүлэх давуу талтай юм.

Монгол Улс визийн ангиллыг хуулиар хатуу тогтоож өгсөн байдаг нь цаг үеийн шаардлага, олон улсын нөхцөл байдалд нийцүүлэн визийн шинэ ангилал нэмэх, өөрчлөх зэрэг зохицуулалт хийх боломжгүйд хүргэдэг Иймээс визийн ангиллыг төрөлжүүлж, олшруулах боломжийг бүрдүүлэх үүднээс визийн ангиллыг хуулиар хатуу тогтоож байгааг өөрчлөн виз олгох журмын дагуу Засгийн газар тогтоодог байх нь зүйтэй байна. Энэ нь олон улсын нийтлэг жишиг бөгөөд ангиллыг олон болгох, хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн тохируулга хийх боломжийг бий болгох, нөхцөл байдалд тохируулан хурдан шуурхай бөгөөд уян хатан шийдвэрийг цаг алдалгүй гаргах зэрэг олон талын ач холбогдолтой юм.

Гадаад улс орнууд виз мэдүүлэх үйл ажиллагаатай холбоотой визийн материалын бүрдлийг хянах, зөвлөгөө, мэдээлэл өгөх зэрэг техникийн чанартай ажиллагааг визийн төв буюу хувийн хэвшлийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлэх чиг хандлагыг баримталж байгаа бөгөөд манай улсын хувьд ч мөн Монгол Улсын визийг олон тоогоор мэдүүлдэг улс орнуудад визийн төв ажиллуулах шаардлагатай байгаа тул энэ талаарх зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай байна. Энэ нь гадаад улс оронд Монгол орныг сурталчлах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, гадаадын иргэдэд хүргэх үйлчилгээг ойртуулах, виз олгохтой холбоотой хууль бус дундын зуучлалыг багасгах, дипломат төлөөлөгчийн газруудын ачааллыг бууруулах, визийн мэдүүлэгт тавих хяналтыг сайжруулах зэрэг ач холбогдолтой юм.

Монгол Улсад 30 хоногоос дээш хугацаагаар ирсэн гадаадын иргэн тус улсад орж ирсэн өдрөөс хойш ажлын долоон өдрийн дотор бүртгүүлдэг байхаар гадаадын иргэдийн бүртгэлийг хуульд тусгасан байна. Гэтэл дэлхийн улс орнууд техник технологийн хөгжлийг ашиглан гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрэх үед бие давхцахгүй өгөгдөл буюу гарын хурууны хээ, царай, нүд зэргээр бүртгэж байгаа

бөгөөд энэ нь гадаадын иргэнд бий болдог хүнд суртлыг бууруулах, төр нэгдмэл, үнэн мэдээллийн сантай болсноор хяналтын тогтолцоог сайжруулах зэрэг олон талын ач холбогдолтой юм. Иймд Монгол Улсын гадаадын иргэний бүртгэлтэй холбоотой зохицуулалтыг өөрчилж хилийн боомтоор нэвтрэх үед биеийн давхцахгүй өгөгдлийг авч бүртгэдэг байх, гадаадын иргэнийг орон байр, сууцаар хангасан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага 48 цагийн дотор тэдгээрийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн байгууллагад цахимаар бүртгүүлдэг байх, оршин суугч гадаадын иргэнд бүртгэлийн дугаар олгох, гадаадын иргэнийг урьсан хугацаанаас үл хамааран уригчийн хариуцлагыг дээшлүүлэх зохицуулалтыг хуульд оруулах шаардлагатай зүйтэй байна.

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах тухай асуудлыг зохицуулсан боловч тодорхой хүндэтгэн үзэх шалтгаантай иргэнийг албадан гаргахаас чөлөөлөх тухай асуудлыг зохицуулалтгүй орхигдуулсан байна. Гэтэл практикт гадаадын иргэн нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болох, гадаадын иргэний гэр бүлийн болон хувийн нөхцөл байдал, ар гэрийн гачигдал, эрүүл мэнд зэрэг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас визийн хугацааг хэтрүүлсэн байх тохиолдол гардаг болно. Энэ тохиолдолд зохицуулалтгүй хэдий ч албадан гаргах ажиллагааг хэрэгжүүлж байгаа нь хүний эрхийн наад захын зарчмыг алдагдуулахад хүргэж байна.

Иймд албадан гаргахаас чөлөөлөх зохицуулалт хуульд байхгүй байгаагаас гадаадын иргэн хохирч байгааг өөрчлөн, хуульд заасан хүндэтгэн үзэх шалтгаантай бол албадан гаргахаас чөлөөлдөг байх зохицуулалт болон иргэний журмаар шүүхэд гомдол гаргасан бол шүүгчийн шийдвэрээр албадан гаргах ажиллагааг түдгэлзүүлэхтэй холбоотой зохицуулалтыг хуульд бий болгох шаардлагатай байна.

Түүнчлэн олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт зөвшөөрөл олгох, сунгах, хүчингүй болгох асуудал зохицуулалтгүй байгааг өөрчилж, тэдний үйл ажиллагаанд нь хяналт тавих журмыг батлах эрхийг гадаадын иргэний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хуулиар олгох шаардлага тулгарч байна.

### **Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Хуулийн төсөл нь Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хэлбэрээр боловсруулагдана. Хуулийн төсөлд дараах зарчмын асуудлыг тусган боловсруулна. Үүнд:

Монгол Улсын визийн тодорхойлолтыг өөрчилж, цахим виз, визийн төвийн тухай, Монгол Улсын хилийн боомт дээр олгох визийн тухай болон визийн ангиллыг Засгийн газраас виз олгох журмаар тогтоодог байхаар тусгана.

Гадаадын иргэний бүртгэлийг сайжруулах зорилгоор гадаадын иргэнийг улсын хилээр нэвтрэх үед хилийн боомт дээр биеийн давхцахгүй өгөгдлөөр бүртгэх тухай болон бүртгэлийн дугаар олгох харилцааг нарийвчлан журамлана.

Гадаадын иргэнийг албадан гаргахаас чөлөөлөх үндэслэлийг хуульд зааж, Иргэний журмаар нэхэмжлэл гаргасан тохиолдолд албадан гаргах ажиллагааг түдгэлзүүлэх тухай зохицуулалтыг тусгана.

Олон улсын болон гадаад улсын төрийн бус байгууллагын салбар, төлөөлөгчийн газарт Монгол Улсад үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл олгох,

сунгах, хүчингүй болгох, үйл ажиллагаанд нь хяналт тавихтай холбоотой зохицуулалт, хууль ёсны хамтран амьдрагчийн тухай ойлголтыг хуульд тусгах замаар гадаадын иргэний эрх зүйн байдалтай холбоотой хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсэж болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар**

Энэхүү хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Их Хурлаас баталсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль тогтоомжийг боловсронгуй болгох үндсэн чиглэлийн холбогдох заалтууд хэрэгжихийн зэрэгцээ гадаадын иргэдэд хүргэх төрийн үйлчилгээ хөнгөн шуурхай болж улмаар гадаад улс оронд Монгол орныг сурталчлах, аялал жуулчлалыг хөгжүүлэх, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, гадаадын иргэний виз, бүртгэлийн тогтолцоо боловсронгуй болж, олон улсын жишигт нийцэхийн хэрэгцээ, эдгээрийг дагалдан гадаадын иргэдэд хяналт тавих механизм сайжрах зэрэг эерэг үр дүн гарна.

**Дөрөв.Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар**

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төслийг дагалдуулан Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулна.

-----oOo-----